



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 0/159

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/990 дүгээр захирамж, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2019 оны А/369, А/500 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гранд слаб” ХХК-тай байгуулсан “960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Нарны хороолол/” НӨАУГ-ББТТ-2019/01 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, тохижилтын эд хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, тохижилтын эд хөрөнгийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг 2019 оны 12 дугаар сарын 16-ны дотор зохион байгуулахыг Ажлын хэсэг /А.Мөнгөн/ -т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001477

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны .12. сарын .11-ний өдрийн 0/559 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	А.Мөнгөн	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд	Н.Раднаасэд	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Т.Баасанцэцэг	Баянгол дүүргийн 141 дүгээр сургуулийн захирал
	Д.Долгорсүрэн	Баянгол дүүргийн 262 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
Нарийн бичгийн дарга	Х.Баттуяа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн